

Тав уу?

засгийн хувьд ямар ч хэмнэлт гарахгүй. Харин хүрээлэнгүүдийн байр байшин сулрахаас эхлээд өөр зүйл хайсан нэгэнд боломж бололцоо аль аль нь хангалттай гарах юм билээ.

Манай дарга нарын гайхуулж цэцэрхээд байдаг гадаадын өндөр хөгжилтэй орнууд шинжлэх ухааны тэргүүлэх хүрээлэнгүүдээрээ гоёдог. Тухайлбал, АНУ гэхэд НАСА-гаар, Герман Макс Планкийн гэхчилэн судалгааны том төв, үндэсний хүрээлэнгүүдээрээ нэрийн хуудас хийдэг гэдгийг захын нэгэн гадарлана. Тиймээс эдгээр хүрээлэнгүүдээ бие даалгах, аль болохоор хөрөнгө мөнгөөр дэмжих бодлого барьдаг. Түүнээс биш манайх шиг бакалаврын сургалтын төлбөр хэдхэн төгрөгөөрөө сургалт явуулсан болж байдаг сургуулиуд нь шинжлэх ухааныг хөгжүүлээд нэрийн хуудас нь болж гялалзаад явдаг түүх ч, туршлага ч байхгүй. Тэгээд ч Балба гэж ядуу буурайгаараа алдартай жижиг улсаас ч бага мөнгө шинжлэх ухааны салбартаа өгчихөөд үр дүн, хөгжил дэвшил нэхээд сууж байдаг манай оронд үндэсний хүрээлэнгүүдээ их сургуулийнхаа малгай дор аваачаад хийчих нь үнэндээ бол шинжлэх ухааныг мөхлийн замд нь хурдхан хүргэж өгч буйгаас өөрцгүй юм.

УЛСТӨРЧИД, НАМУУД ИРГЭДИЙН ИТГЭЛИЙГ БҮРМӨСӨН АЛДЖЭЭ

Ө.СОНОР

Нээлтэй нийгэм форумын захиалгаар “Сант марал” сангийнхан өнгөрсөн сарын эхэнд нэгэн улс төрийн судалгаа явуулжээ. Улс төрийн намуудын санхүүжилтийн ил тод байдал, санхүүжилтийн арга хэлбэр, түүнийг боловсронгуй болгоход олон нийтийн санаа бодлыг тандах зорилготой уг судалгааг нийслэл болон Говьалтай, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Ховд, Хөвсгөл аймгийн 1200 өрхөөс авсан байна. Судалгааг өнгөрсөн сарын 1-нээс 17-ны өдөр авсан нь Засгийн газар солигдох үетэй таарсан учир нэлээд сонирхолтой үр дүн гарсан гэж үзэж буй юм. 18-аас дээш насны иргэдээс санамсаргүй түүврийн болон ганцаарчилсан ярилцлага хийж авсан судалгааны дүнг сонирхвол иргэд улстөрчид болон намуудад бүрмөсөн итгэхээ больсон хэмээх дүгнэлтэд хүрч болохоор байгаа юм. “УИХ-ын гишүүд шийдвэр гаргахдаа сонгогчдын бус явцуу эрх ашгаа эхэнд тавьдаг уу” гэсэн асуултад иргэдийн 51,9 хувь нь тийм гэж хариулжээ. Өнөөгийн УИХ улс орны өмнө тулгарч буй асуудлыг

шийдэж чадахгүй гэж 52,9 хувь нь үзсэн бол ардчиллыг сулруулж байгааг 34,2 хувь нь хүлээн зөвшөөрсөн байна. “Улс төрчид дэндүү их цаг хугацаа, идэвхи зүтгэлийг мөнгө олоход зарцуулж байна” гэсэн агуулгад иргэдийн 45,2 хувь нь бүрэн санал нийлж байна гэдэг хариултыг дугуйлжээ. Судалгаанд оролцогчдын олонх намуудын одоогийн санхүүжилтийн тогтолцоо нь шударга ёсонд огт нийцэхгүй байна гээд намуудын сонгуулийн үеийн санхүүжилтийг төсвийн мөнгөнөөс буюу иргэдийн татварын мөнгөнөөс олгохыг бүрэн дэмжихгүй гэдэгт олуулаа санал нэгджээ.

Энэхүү судалгаатай

холбоотойгоор та өмнөх УИХ-ын сонгуульд саналаа өгсөн үү гэдэгт 90 орчим хувь нь “Тийм” гэж хариулсан нь бодит дүнтэй жаахан зөрчилдөж буй юм. Магадгүй иргэд сонгууль өгөөгүй байсан ч өгсөн гэж хариулдаг учраас ийм үр дүн гарсан байх гэж судалгааны багийнхан үзэж байна. Та улс төрийн аль намыг онцолж үздэг вэ гэсэн асуултад 31,1 хувь нь МАН, 54 хувь нь АН, 12,9 нь МАХН, 1,4 нь ИЗНН гэж хариулсан ажээ. Харин та аль намын гишүүн бэ гэдэгт 39,8 нь МАН, 45,2 нь АН, 12,2 нь МАХН-ыг тэмдэглэсэн байна. Энэхүү судалгааны талаар дэлгэрэнгүйг www.polit.mn цахим хуудаснаас үзээрэй.

Та өмнөх УИХ-ын сонгуульд оролцож саналаа өгсөн үү?

	Хөдөө	Хот	Нийт
Тийм	90.2%	84.5%	87.6%
Үгүй	9.8%	15.5%	12.4%

Та улс төрийн аль намыг онцолж үздэг вэ?

	Хөдөө	Хот	Нийт
Монгол Ардын Нам	37.0%	23.5%	31.1%
Ардчилсан Нам	53.0%	55.3%	54.0%
МАХН	9.3%	17.5%	12.9%
Иргэний Зориг-Ногоон нам (Хариулаагүй)	.7%	2.3%	1.4%
	1.4%	.6%	

Та намын гишүүн бол аль намын гишүүн бэ?

	Хөдөө	Хот	Нийт
Монгол Ардын Нам	43.0%	31.7%	39.8%
Ардчилсан Нам	48.1%	38.1%	45.2%
МАХН	8.2%	22.2%	12.2%
Иргэний Зориг-Ногоон нам (Хариулаагүй)	.6%	1.6%	.9%
	6.3%	1.8%	

Улс төрд мөнгөний үзүүлж байгаа нөлөөг бууруулахтай холбоотой дор дурдсан саналуудыг Та хэр дэмжиж байгаагаа тодорхойлно уу?

Сонгуулийн кампанит ажлын зардлыг улсаас бүрэн даах

	Хөдөө	Хот	Нийт
Маш их	12.8%	7.8%	10.5%
Тодорхой хэмжээнд	25.1%	20.7%	23.1%
Бага зэрэг	15.5%	12.2%	14.0%
Огт үгүй (Мэдэхгүй)	34.0%	46.7%	39.8%
(Хариулаагүй)	11.7%	10.5%	11.2%
	.9%	2.0%	1.4%

УИХ-ын гишүүд шийдвэр гаргахдаа сонгогчдын эрх ашиг гэхээсээ явцуу эрх ашгийг урьтал болгодог.

	Хөдөө	Хот	Нийт
Маш их нийцэж байна	50.8%	53.3%	51.9%
Тодорхой хэмжээнд нийцэж байна	31.5%	31.1%	31.3%
Бага зэрэг нийцэж байна	5.4%	6.9%	6.1%
Огт нийцэхгүй байна (Мэдэхгүй)	6.2%	5.3%	5.8%
(Хариулаагүй)	6.0%	3.3%	4.8%
	.2%	.2%	.2%

УИХ улс орны өмнө тулгарч байгаа томоохон асуудлуудыг шийдвэрлэж чадахгүй байдалд хүрч байна.

	Хөдөө	Хот	Нийт
Маш их нийцэж байна	50.0%	56.4%	52.9%
Тодорхой хэмжээнд нийцэж байна	30.5%	28.9%	29.8%
Бага зэрэг нийцэж байна	10.3%	7.6%	9.1%
Огт нийцэхгүй байна (Мэдэхгүй)	2.5%	2.2%	2.3%
(Хариулаагүй)	6.6%	4.7%	5.8%
	.2%	.2%	.2%

Улс төрчид дэндүү их цаг хугацаа, идэвхи зүтгэлийг мөнгө олоход зарцуулж байна.

	Хөдөө	Хот	Нийт
Огт санал нийлэхгүй байна	.6%	2.2%	1.3%
Санал нийлэхгүй байна	2.5%	1.8%	2.2%
Дунд зэрэг	9.8%	10.2%	10.0%
Санал нийлж байна	32.8%	33.8%	33.3%
Бүрэн санал нийлж байна (Мэдэхгүй)	43.4%	47.3%	45.2%
(Хариулаагүй)	10.8%	4.7%	8.0%
	.2%	.1%	

ШИЛЭН ДАНСНЫ ХУУЛЬ ХЭРЭГЖИЖ ЭХЛЭХЭД

7

ХОНОГ ҮЛДЛЭЭ

2015 оны 1 дүгээр сарын 1 -нээс мөрдөнө.

“ЗУУНЫ МЭДЭЭ”-Г ОНЛАЙНААР ЗАХИАЛАН УНШААРАЙ

<http://zuuniimedee.imedia.mn>

Та “Зууны мэдээ” сониныг дэлхийн хаанаас ч, гэртээ сууж байгаад захиалан унших боломжтой.



Манай сонины цахим хувилбар нь таны цаг зав, мөнгийг хэмнэнэ. Сард ердөө 5000, улиралд ердөө 10.000 төгрөг